



**ХЭНТИЙ АЙМГИЙН
ДАДАЛ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2025 оны 05 сарын 30 өдөр

Дугаар А/М

Дадал сум

Тээврийн хэрэгслийн татвар хураалт,
техникийн үзлэг явуулах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, 60 дугаар зүйлийн 60.1.1, Авто тээврийн болон өөрөө явагч хэрэгслийн албан татварын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1, 7 дугаар зүйлийн 7.1 дэх хэсэг, Авто тээврийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.1, аймгийн Засаг даргын 2025 оны 01 дүгээр сарын 29-ны өдрийн А/37 дугаар захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Сумын хэмжээнд авто тээврийн татвар хураалт, техникийн хяналтын үзлэг 2025 оны 06 дугаар сарын 02-04-ний өдрүүдэд зохион байгуулагдах тул ажлын хэсгийг дараахь бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Дарга	Ж.Хоридой	(Засаг даргын орлогч)
Нарийн бичгийн дарга	С.Тэмүүлэн	(Татварын улсын байцаагч)
Гишүүд	О.Дугар	(Онон багийн Засаг дарга)
	А.Анар	(Балж багийн Засаг дарга)
	Г.Ган-Эрдэнэ	(Агац багийн Засаг дарга)
	Б.Эрдэнэчулуун	(Баян-Овоо багийн Засаг дарга)
	Г.Билгүүн	(Хэсгийн төлөөлөгч)

2.Автотээврийн хэрэгслийн техникийн хяналтын оношлогоонд өөрийн багийн нутаг дэвсгэрт байгаа бүх тээврийн хэрэгслийг бүртгэл судалгааны дагуу бүрэн хамруулах, техник оношлогооны өмнө автотээврийн хэрэгслийн албан татвар, орон нутгийн авто зам ашигласны төлбөрийг хураан авах ажлыг зохион байгуулсан байхыг Татварын улсын байцаагч, багийн Засаг дарга нарт тус тус үүрэг болгосугай.

3.Автотээврийн хэрэгслийн татвар хураалт, техникийн хяналтын үзлэг оношлогоонд ороогүй тээврийн хэрэгслийг замын хөдөлгөөнд оролцохыг хориглон зөрчлийг арилгуулан, графикт үзлэг оношлогооноос хоцорсон тээврийн хэрэгслийг техникийн үзлэгт нөхөн оруулах арга хэмжээ авч ажиллахыг Хэсгийн төлөөлөгч (Г.Билгүүн), тээврийн хэрэгслийн татвар хураалт, техникийн хяналтын үзлэг оношлогооны үйл ажиллагааг дүгнэн, дүнг танилцуулахыг ажлын хэсгийн ахлагч (Ж.Хоридой) нарт тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА

Ш.МӨНХХУЯГ



010000320